



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

┌ Жуулчин тээврийн автобусанд зөвшөөрөл олгох тухай ┐

Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/469 дугаар захирамж, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын дугаарын хязгаарлалтгүйгээр нийслэл хотын авто замын хөдөлгөөнд оролцох 8-с дээш хүний суудалтай жуулчин тээврийн автобусанд олгох зөвшөөрлийн загварыг хавсралтаар баталсугай.

2. Уг зөвшөөрлийг "Жуулчны авто тээврийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5231:2003" стандартын шаардлага хангасан "Жуулчин" наалт бүхий автобусанд эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн өдөрт нь олгож байхыг Жуулчны аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/-д даалгасугай.


3. Зөвшөөрөл хэвлүүлэх зардлыг батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2015 оны 06 сарын 07 ний өдрийн
А/47 тоот тушаалын хавсралт



УЛСЫН ДУГААРЫН ХЯЗГААРЛАЛТГҮЙГЭЭР НИЙСЛЭЛ ХОТЫН АВТО ЗАМЫН
ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН АВТОБУСАНД ОЛГОХ
ЗӨВШӨӨРЛИЙН ЗАГВАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ЗӨВШӨӨРӨЛ

20... оны ... дугаар сарын ... ний өдөр № ... Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/469 дугаар захирамжийг үндэслэн
... улсын дугаартай ... маркын
жуулчин тээврийн автобусанд дугаарын хязгаарлалтгүйгээр нийслэл хотын
авто замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрлийг олгов.

ДАРГА Э.БАТТУЛГА

Энэхүү зөвшөөрөл нь 2015 оныг дуустал хүчинтэй.

НАЙРСАГ УЛААНБААТАР
HOSPITABLE ULAANBAATAR

**ЖУУЛЧИН
ТЭЭВЭР**

